



ОРХОН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛ,  
СТАТИСТИКИЙН ГАЗРЫН  
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



АЙМГИЙН ХҮН АМ, ӨРХИЙН  
ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Орхон аймаг  
2016 он

## Танилцуулгын агуулга

- Оршил
  - Танилцуулгын зорилго
  - Танилцуулгын аргачлал
- Хүн амын тооны өсөлт, нас, хүйсийн бүтэц
  - Хүн амын тоо, байршил
  - Хүн амын өсөлт
  - Хүн амын нас, хүйсийн бүтэц
  - Хүн ам зүйн ачаалал
  - Хүн амын насжилт
  - Хүйсийн харьцаа
  - Өрхийн тоо, байршил
- Хүн амын ердийн хөдөлгөөн
  - Төрөлт
  - Нас баралт
  - Гэрлэлт
  - Цуцлалт
  - Үрчлэлт
- Өрх, хүн амын нийгмийн зарим үзүүлэлтүүд
  - Өнчин болон хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхэд
  - Өрх толгойлсон эмэгтэйчүүд
  - Хүүхэдтэй гэр бүлгүй хүн ам
- Дүгнэлт
- Хамруулсан хугацаа
- Мэдээллийн эх үүсвэр
- Нэр томъёоны тайлбар

## **ОРШИЛ**

Хүн амын өсөлт, нас хүйсийн бүтэц, түүний өөрчлөлт нь нийгэм, эдийн засагт шууд болон шууд бусаар нөлөөлж байдаг бөгөөд хүн амд чиглэсэн ямар бодлого, хөтөлбөр боловсруулах вэ гэдгийг тодорхойлоход чухал ач холбогдолтой.

Иймд хүн ам, өрхийн үндсэн үзүүлэлтэд статистикийн арга аргачлалыг ашиглан судалгаа дүгнэлт хийж, төлөв байдлыг тодорхойлох нь зүй ёсны шаардлага болно.

### **Танилцуулгын зорилго**

Энэхүү танилцуулгад Орхон аймгийн 2014, 2015 оны хүн амын тоо, түүний өсөлт, нас, хүйсийн бүтэц, дундаж нас, наслалт, ердийн болон механик хөдөлгөөний өсөлт бууралт, өрх, хүн амын нийгмийн зарим үзүүлэлтийн байдал, түүнд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг тодорхойлохыг зорилоо.

### **Танилцуулгын аргачлал**

Хүн амын статистикийн албан ёсны мэдээ тайланд тулгуурлан, холбогдох үзүүлэлтүүдийг тооцож, 2014 онтой харьцуулан дүгнэж, статистикийн хүснэгт, графикаар өсөлт бууралтыг харуулж танилцуулгыг хийлээ.

Хүн ам зүйн ойлголт тодорхойлолтыг тусгайлан хийж, нэр томъёоны тайлбар нэрээр оруулав.

## I. Хүн амын тооны өсөлт, нас, хүйсийн бүтэц

Хүн ам зүйн судалгаа нь хүн амын тоо хэмжээ, насны бүтцийг нарийн тооцоход оршино.

### 1. Хүн амын тоо, байршил:

Хүн ам, орон сууцны 2010 оны ээлжит тооллогоор Орхон аймагт 87.1 мянган хүн тоологдож байсан бол 2015 оны завсрын тооллогоор 98.7 мянгад хүрч, тооллогоос 13.3 хувиар, өнгөрсөн оноос 6.5 хувиар нэмэгджээ.

Нийт хүн амын 96.2 хувь буюу 95.0 мянга нь аймгийн төвийн сум буюу Баян-Өндөр суманд, 3.8 хувь буюу 3.8 мянга нь хөдөөгийн сум болох Жаргалант суманд амьдарч байна.

### Хүснэгт 1. Хүн амын тоо, сум, хүйсээр

ОН	Нийт хүн ам	Үүнээс: хүйсээр		БҮГДЭЭС					
		эрэгтэй	эмэгтэй	Баян-Өндөр сум			Жаргалант сум		
				Бүх хүн ам	үүнээс		Бүх хүнам	үүнээс	
эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй		эрэгтэй	эмэгтэй			
2014	92705	45445	47260	88670	43334	45336	4035	2111	1924
2015	98750	48492	50258	94976	46506	48470	3774	1986	1788

Жаргалант сумын хүн амын тоо 2014 оноос 6.5 хувиар буурсанд Малчин баг татан буугдахтай холбоотойгоор Малчин багийн иргэд мал маллах газар нутгаас шалтгаалж зэргэлдээх аймаг, сум руу шилжсэн нь нөлөөлсөн.

### Хүснэгт 2. Хүн амын тоо, байршлаар

		2014	2015
Нийт хүн амын тоо		92705	98750
үүнээс:	эрэгтэй	45445	48492
	эмэгтэй	47260	50258
бүгдээс:	аймгийн төвд	88670	94976
	сумын төвд	2279	2336
	хөдөөд	1756	1438

Нийт хүн амын 96.2 хувь нь аймгийн төвд, 2.4 хувь нь сумын төвд, 1.4 хувь нь хөдөө оршин сууж байна. Аймгийн төвийн хүн амын эзлэх хувийн жин өмнөх оноос 0.6 пунктээр нэмэгдэж, сумын төв


болон хөдөөд амьдардаг хүн амын хувийн жин 0.1-0.4 пунктээр буурчээ.

ХҮН АМ, ӨРХИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Хүснэгт 3. Хүн амын тоо, багаар

	2014	2015
<b>Баян-Өндөр сум - бүгд</b>	<b>88670</b>	<b>94976</b>
Зэст	4282	4888
Оюут	5101	5512
Уурхайчин	5511	5450
Хүрэнбулаг	4980	5086
Уртбулаг	3927	4363
Согоот	5158	4973
Дэнж	5423	5806
Бүрэнбүст	3659	3880
Шанд	2446	2517
Наран	3848	3895
Цагаанчулуут	4078	4439
Булаг	3476	3301
Баянцагаан	5219	5521
Говил	3436	3540
Рашаант	4661	4685
Эрдэнэ	5677	6556
Баянбулаг	3263	3167
Их залуу	3630	4253
Даваат	4086	4630
Яргуйт	4059	5558
Уртын гол	2750	2956
<b>Жаргалант сум - бүгд</b>	<b>4035</b>	<b>3774</b>
Улаантолгой	990	1071
Жаргалант	1289	1265
Дулаан-Уул	985	1141
Малчин	771	297
<b>АЙМГИЙН ДҮН</b>	<b>92705</b>	<b>98750</b>

Зураг 1. Хүн амын тоо, багаар, бүтцээр, 2015 он



Нийт 25 багийн 28.0 хувь нь (Оюут, Уурхайчин, Хүрэнбулаг, Дэнж, Баянцагаан, Эрдэнэ, Яргуйт баг) 5.0 мянгаас дээш хүн амтай бол 16.0 хувь нь (Малчин, Дулаан-Уул, Улаантолгой, Жаргалант баг) 0.3-1.3 мянган хүн амтай байна. Багуудын дийлэнх буюу 76.0 хувь нь 3.0 мянгаас дээш хүн амтай ажээ.

## ХҮН АМ, ӨРХИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ


Аймгийн дүнгээр нэг км<sup>2</sup> нутаг дэвсгэрт 117 хүн ногдож, хүн амын нягтрал улсын дунджаас 58.5 дахин их байна.

Нэг км<sup>2</sup> нутаг дэвсгэрт ногдох хүний тоо Баян-Өндөр суманд 474.9 байхад Жаргалант суманд 4.7 байгаа нь аймгийн дунджаас Баян-Өндөр сумынх 4.1 дахин их, Жаргалант сумынх 24.9 дахин бага байна.

### 2. Хүн амын өсөлт

Аймгийн хүн амын тооны жилийн дундаж өсөлтийн хувь 2015 онд өмнөх оноос 4.8 пунктээр их байна.

Зураг 2. Хүн амын өсөлт, бууралт, хувиар, 2011-2015 он



Хүн амын өсөлтийг цэвэр шилжилт, ердийн цэвэр өсөлтөөр тооцдог. Цэвэр шилжилт нь шилжин ирсэн, явсан хүний зөрүүгээр хүн амын механик хөдөлгөөний дүнд гардаг ба аймгийн цэвэр шилжилт 2015 онд (-889 хүн) хасах үзүүлэлттэй гарсан нь шилжин явах урсгал давамгайл байгааг илэрхийлнэ. Энэ нь 2014 оныхоос 1264 хүнээр бага байна.

Хүснэгт 4. Хүн амын цэвэр өсөлт

ОН	Жилийн дундаж хүн ам	Механик хөдөлгөөн			Ердийн хөдөлгөөн			1000 хүн амд ногдох		
		Шилжиж ирсэн	Шилжин явсан	Цэвэр шилжилт	Төрсөн хүүхэд	Нас барсан хүн	Ердийн цэвэр өсөлт	Төрөлт	Нас баралт	Цэвэр өсөлт
2014	91920	2132	4285	-2153	2516	625	1891	27.4	6.8	20.6
2015	95728	2374	3263	-889	2352	569	1783	24.6	5.9	18.6

Цэвэр өсөлт нь ердийн хөдөлгөөний дүнд гардаг ба төрсөн хүүхэд, нас барсан хүний тооны зөрүүгээр тооцогддог ба 2015 онд (+1783) нэмэх

ХҮН АМ, ӨРХИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

үзүүлэлттэй байгаа нь аймгийн хүн амын өсөлтөд ердийн цэвэр өсөлт шууд нөлөөлж буйг харуулж байна.

**3.Хүн амын нас, хүйсийн бүтэц**

Нийт хүн амын 29.8 хувийг 0-15 насны хүүхэд, 64.4 хувийг хөдөлмөрийн насны хүн ам, 5.8 хувийг тэтгэврийн насны хүн ам эзэлж байна.

Хүснэгт 5. Хүн амын тоо, насны бүлгээр

Он	БҮГД	үүнээс:					
		0-15 насны хүүхэд	%	Хөдөлмөрийн насны	%	Тэтгэврийн насны	%
<b>2014</b>	92705	25621	27.6	61765	66.6	5319	5.8
<b>2015</b>	98750	29432	29.8	63605	64.4	5713	5.8

Нийт хүн амд 0-15 насны хүүхдийн эзлэх хувь 2014 оноос 2.2 пунктээр нэмэгдэж, хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь 2.2 пунктээр буурч, тэтгэврийн насны хүн амын хувьд өмнөх оны түвшинд байна.

**4.Хүн ам зүйн ачаалал**

Энэ нь тэжээгчийн тэжээж буй хүний тоог харуулдаг ба хүүхэд насны хүн ам зүйн ачаалал, өндөр настны хүн ам зүйн ачаалал, ерөнхий хүн зүйн ачаалал гэж 3 хувааж үздэг.


Ерөнхий хүн ам зүйн ачаалал нь хөдөлмөрийн насны нэг хүнд хөдөлмөрийн бус насны хичнээн хүн ногдож байгааг харуулна.

Хүснэгт 6. Хүн ам зүйн ачаалал

î í	ÀxÀÄÈÀË			
	Äðí ðèé		Õ ã ÷ ÿ è è é í	Õ ÿ ä ä è é í
	(100 ð ÿ í ä)	(1 ð ÿ í ä)	(100 ð ÿ í ä)	(100 ð ÿ í ä)
<b>2014</b>	50.1	0.5	8.6	41.5
<b>2015</b>	55.3	0.6	9.0	46.3

2015 онд хөдөлмөрийн насны 100 хүнд 55 тэжээлгэгч ногдож байна.

Зураг 3. Хүн ам зүйн ачаалал



2015 онд 46 хүүхэд, 9 өндөр настан ногдож байна. Өөрөөр хэлбэл хөдөлмөрийн насны 10 хүн хөдөлмөрийн бус насны 6 хүнийг, үүнээс 5 хүүхэд, 1 өндөр настанг тэжээж байна.

Ерөнхийдөө тэжээлгэгчийн тоо хөгшчүүлийн хувьд өмнөх оны түвшинд, хүүхдийн хувьд өмнөх оноос 4.8-аар их байна.

### 5. Хүн амын насжилт

Хүн амыг насны бүтцийнх нь хувьд яг таллан хувааж байгаа насыг *насны голч* гэнэ.

#### Хүснэгт 7. Хүн амын голч нас

Он	Аймаг			үүнээс: сумаар					
				Баян-Өндөр			Жаргалант		
	Бүгд	эрэгтэй	эмэгтэй	Бүгд	эрэгтэй	эмэгтэй	Бүгд	эрэгтэй	эмэгтэй
2014	29.0	28.1	29.9	29.0	28.0	29.9	30.1	28.9	31.5
2015	28.63	27.67	29.55	28.57	27.61	29.48	30.15	28.96	31.48

Аймгийн хүн амын голч нас өмнөх оны түвшинд байна. Баян-Өндөр сумын хувьд аймгийн дундажтай ижил түвшинд, Жаргалант сумын эрэгтэйчүүдийн дундаж нас 1.3 жилээр, эмэгтэйчүүдийнх 1.9 жилээр илүү байна.

### 6. Хүйсийн харьцаа

Энэ нь 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоогоор илэрхийлэгддэг.

#### Хүснэгт 8. Хүйсийн харьцаа

Он	Хүйсийн харьцаа*		
	Аймаг	Баян-Өндөр	Жаргалант
2014	96.16	95.58	109.72
2015	96.49	95.95	111.07

Аймгийн хэмжээнд хүйсийн харьцаа 2014, 2015 онуудад 96 байна. Баян-Өндөр сумын

ХҮН АМ, ӨРХИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

хүн амын хүйсийн харьцаа аймгийн дунджаас 0.5 нэгжээр доогуур, харин Жаргалант сумын хувьд 14.6 нэгжээр дээгүүр байна. Хүн амын хүйсийн харьцаа 2014 оноос 0.3 нэгжээр нэмэгджээ.

7. Өрхийн тоо, байршил

2015 онд аймгийн нийт өрхийн тоо 28.1 мянгад хүрч, өмнөх оноос 8.1 хувиар буюу 2.1 мянгаар нэмэгдсэн байна.

Хүснэгт 10. Өрхийн тоо, байршлаар

Нийт өрхийн 95.9 хувь нь аймгийн төвд, 2.3 хувь нь сумын төвд, 1.8 хувь нь хөдөөд амьдарч байна.

		2014	2015
Нийт өрхийн тоо		25973	28089
бүгдээс:	аймгийн төвд	24734	26929
	сумын төвд	628	647
	хөдөөд	611	513

Аймгийн төвд амьдарч байгаа өрхийн эзлэх хувийн жин 2014 оноос 0.7 пунктээр нэмэгдэж, хөдөөгийн өрх 0.6 пунктээр, сумын төвийн өрх 0.1 пунктээр буурчээ.

Хүснэгт 9. Өрхийн тоо, нэг өрхөд ногдох хүн амын тоо

Он	Нийт өрхийн тоо	Нийт хүн амын тоо	Нэг өрхөд ногдох хүн амын тоо
2014	25973	92705	3.57
2015	28089	98750	3.52

2000, 2001 онд нэг өрхөд ногдох хүний тоо 4.1-4.2 байдаг байснаа 2002 оноос эхлэн энэ үзүүлэлт аажим тасралтгүй буурсаар 2015

онд 3.5 хүн болжээ. Энэ нь сүүлийн жилүүдэд ойролцоо түвшинд байна.


Байршлын хувьд аймгийн төвд 3.5, сумын төвд 3.6, хөдөөд 2.8 хүн нэг өрхөд ногдож байна.

ХҮН АМ, ӨРХИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Хүснэгт 11. Өрхийн тоо, багаар, 2014-2015 он

		2014	2015	
<b>Баян-Өндөр сум - бүгд</b>		<b>24734</b>	<b>26929</b>	
Багаар	Зэст	1196	1360	
	Оюут	1399	1456	
	Уурхайчин	1467	1527	
	Хүрэнбулаг	1395	1454	
	Уртбулаг	1109	1311	
	Согоот	1267	1374	
	Дэнж	1483	1571	
	Бүрэнбүст	957	1115	
	Шанд	722	734	
	Наран	1039	1090	
	Цагаанчулуут	1133	1238	
	Булаг	957	927	
	Баянцагаан	1506	1642	
	Говил	937	977	
	Рашаант	1271	1238	
	Эрдэнэ	1655	1927	
	Баянбулаг	943	917	
	Их залуу	1105	1209	
	Даваат	1144	1283	
	Яргуйт	1250	1686	
	Уртын гол	799	893	
	<b>Жаргалант сум - бүгд</b>		<b>1239</b>	<b>1160</b>
	Багаар	Улаантолгой	286	306
Жаргалант		342	341	
Дулаан-Уул		309	339	
Малчин		302	174	
<b>АЙМГИЙН ДҮН</b>		<b>25973</b>	<b>28089</b>	

Зураг 5. Өрхийн тоо, багаар, 2015 он



Нийт багийн 64.0 хувь (16 баг) нь 1.0 мянгаас дээш өрхтэй бол 16 хувь (4) нь 350 хүртэл өрхтэй байна. Баян-Өндөр сумын багуудаас Эрдэнэ (1927), Яргуйт (1686), Баянцагаан (1642), Дэнж (1571), Уурхайчин (1527) багууд хамгийн их өрхтэй ажээ. **Баянцагаан, Эрдэнэ, Шанд, Дулаан-Уул,** Уртбулаг, Уртын гол, Яргуйт, Малчин багийн нэг өрхөд ногдох хүний тоо аймгийн дунджаас 0.1-1.8

нэгжээр доогуур, Согоот, Даваат, Зэст, Цагаанчулуут, Наран, Уурхайчин, Булаг багийнх 0.1-0.3 нэгжээр дээгүүр, бусад 5 баг аймгийн дундажтай ижил түвшинд байна.

## II. Хүн амын ердийн хөдөлгөөн

### 1.Төрөлт

Төрөлт нь хүн амын нөхөн үржихүйн бодит үзэгдэл бөгөөд эмэгтэйчүүдийн амьд төрүүлсэн хүүхдийн тоогоор тодорхойлогдоно.

Аймгийн хэмжээнд 2015 онд 2352 хүүхэд төрсөн нь өнгөрсөн оноос 6.5 хувиар буурчээ. 2014 онд төрсөн нийт хүүхдийн 51.1 хувийг, 2014 онд 51.2 хувийг эрэгтэй хүүхэд эзэлж байна.

Хүснэгт 12. Төрсөн хүүхдийн тоо, эхийн насаар

Он	Төрсөн хүүхэд - бүгд	Үүнээс: эхийн насаар									Төрөх үеийн хүйсийн харьцаа
		15 хүртэл	15 - 19	20 - 24	25 - 29	30 - 34	35 - 39	40 - 44	45 - 49	50-аас дээш	
2014	2516	-	92	715	819	532	275	75	8	-	105.5
2015	2352	1	72	593	794	456	317	116	3	-	105.1

Төрөх үеийн хүйсийн харьцаа 2015 онд 105.1 болж өмнөх оноос 0.4 нэгжээр бага байгаа нь төрсөн хүүхдийн дунд эрэгтэй хүүхдийн эзлэх жин буурч байгааг харуулж байна. Төрсөн хүүхдийг эхийн насаар нь авч үзвэл 20-29 насны эмэгтэйчүүдийн төрөлт илүү байна.


Төрөлтийн түвшинг тодорхойлдог хэд хэдэн үндсэн үзүүлэлт байдгийн нэг нь *төрөлтийн ерөнхий коэффициент (ТЕК)* юм. ТЕК нь тухайн жилд мянган хүн амд ногдох амьд төрсөн хүүхдийн тоог илэрхийлнэ.

Хүснэгт 13. Төрөлтийн түвшин

Он	ТЕК	Насны бүлгийн ТТК									ТТК	ТНК
		15 хүртэл	15 - 19	20 - 24	25 - 29	30 - 34	35 - 39	40 - 44	45 - 49	50-аас дээш		
2014	27.4	0	24.7	162.7	172.2	135.7	80.2	21	2.3	0	92.2	3.0
2015	24.6	0	19.5	138.4	163	111.1	91	31.7	0.8	0	84.8	2.8

1000 хүнд ногдох төрсөн хүүхдийн тоо 2015 онд 24.6 болж өмнөх оноос 2.8 промилээр буурсан байна.


Зураг 4. Төрөлтийн ерөнхий түвшин



Аймгийн хэмжээнд 1000 хүнд ногдох төрсөн хүүхдийн тоо 2014 онд 27.4, 2015 онд 24.6 промилль байгаа ба сүүлийн 3 жилд жил дараалан буурсан байна. Энэ нь төрөлт болон хүн амын тооны өсөлтөөс шууд шалтгаалдаг.

*Төрөлтийн тусгай коэффициент (ТТК)* нь 15-49 насны 1000 эмэгтэйд ногдох амьд төрсөн хүүхдийн тоог буюу төрөх насны 1000 эмэгтэй тутамд хэдэн төрөлт ногдож байгааг илэрхийлнэ.

Зураг 5. Төрөлтийн тусгай коэффициент



Аймгийн ТТК нь 2014 онд 92.2 байсан бол 2015 онд 84.8 болж, өмнөх оноос 7.4 промилээр буурсан байна .

ТТК нь насны бүлэг дэх төрөлтийн ялгавартай түвшинг харуулж чаддаггүй учир уг коэффициентийг насны бүлэг тус бүрт тооцож, насны бүлэг дэх төрөлтийн түвшинг гаргаж ялгавартай харж болно.

Зураг 6. Насны бүлэг дэх төрөлтийн тусгай коэффициент




*Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент (НБТК)*-ыг 5 насны бүлгээр ангилсан 8 бүлэгт тооцлоо. 2014 онд 25-29 насны 1000 эмэгтэйд 172.2, 2015 онд 25-29 насны 1000 эмэгтэйд 163.0 төрсөн хүүхэд ногдож

байна. Энэ үзүүлэлт 25-29 насны бүлэгт өмнөх оноос 9.2 промилээр буурсан байхад 35-39 насны бүлэгт 10.8 промилээр нэмэгдсэн ба 20-29 насны бүлгийн эмэгтэйчүүдийн төрөлтийн түвшин хамгийн өндөр байгаа нь харагдаж байна.

*Төрөлтийн нийлбэр коэффициент (ТНК)* нь төрөлтийн түвшинг илэрхийлэх чухал үзүүлэлт бөгөөд нас баралтын түвшинг тооцоогүй тохиолдолд нэг эмэгтэйн эсвэл 1000 эмэгтэйн нийт амьдралынхаа туршид төрүүлэх хүүхдийн дундаж тоог илэрхийлнэ.

Зураг 7. Төрөлтийн нийлбэр коэффициент

ТНК 2014 онд 3.0 байснаа 2015 онд 2.8 болж, өмнөх оноос 0.2 промилээр буурсан байна. ТНК нь тухайн жилд амьд төрсөн хүүхдийн тоо, хүн амын тооны өсөлттэй шууд холбогдон өсч буурч байдаг.



## 2. Нас баралт

Нас баралт нь хүн амын дунд гарч буй нөхөн үржихүйн үзэгдэл юм. Нас баралт нь тухайн газар нутгийн хүн амын нас, хүйсийн бүтэц, ажил эрхлэлтийн байдал болон нийгмийн тодорхой анги бүлэг, байршил гэх мэт олон хүчин зүйлээс шалтгаалан харилцан адилгүй түвшинтэй байдаг. Түүнчлэн хүн амын амьжиргааны түвшин, эрүүл ахуйн нөхцөл байдал ч нас баралтын түвшинд нөлөөлдөг.

Аймгийн хэмжээнд 2014 онд 625 хүн нас барсан нь өмнөх оноос 9.3 хувиар их байна.

### Хүснэгт 12. Нас барсан хүний тоо, насны бүлгээр

Он	Нас баралт- бүгд	Үүнээс: эмэгтэй	үүнээс:														
			0 - 4	5 - 9	10 - 14	15 - 19	20 - 24	25 - 29	30 - 34	35 - 39	40 - 44	45 - 49	50 - 54	55 - 59	60 - 64	65 - 69	70 ба дээш
2014	625	253	24	5	4	4	10	14	20	25	35	48	69	65	52	51	199
2015	569	209	22	4	0	6	10	25	13	21	31	47	48	86	54	39	163

2014 онд нийт нас барсан хүний 59.5 хувь нь, 2015 онд 63.3 хувь нь эрэгтэйчүүд байна. 2015 онд нас барсан нийт хүн амын 28.6 хувийг 70 ба

ХҮН АМ, ӨРХИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

түүнээс дээш насныхан, 23.5 хувийг 50-59 насныхан, 16.4 хувийг 60-69 насныхан, 13.7 хувийг 40-49 насныхан, 3.9 хувь нь 0-4 насны хүүхэд байна.


Хүснэгт 12. Нас баралтын түвшин

Он	НБЕК	Насны бүлэг дэх НБК														
		0 - 4	5 - 9	10 - 14	15 - 19	20 - 24	25 - 29	30 - 34	35 - 39	40 - 44	45 - 49	50 - 54	55 - 59	60 - 64	65 - 69	70 ба дээш
2014	6.8	2.4	0.6	0.6	0.5	1.1	1.4	2.6	3.7	5.2	7.5	11.7	18.4	27	43.3	89.8
2015	5.8	1.8	0.4	0.0	0.8	1.1	2.5	1.6	3.0	4.5	7.0	7.9	20.1	25.6	29.0	72.3

НБЕК нь тухайн жилд 1000 хүнд ногдох нас барагсдын тоогоор илэрхийлэгддэг. 2014 онд аймгийн 1000 хүн тутмын 6.8, 2015 онд 5.8 хүн нас барж, НБЕК 2015 онд өмнөх оноос 1.0 промилээр буурчээ.

НБЕК нь нас баралтыг насны бүлгээр тодорхойлдоггүй учир нас баралтын түвшинг насны бүлэг тус бүрд тооцдог. Энэ нь насны бүлэг тус бүрд нас баралтын түвшин харилцан адилгүй байгааг харуулдаг.

Зураг 8. Насны бүлэг дэх нас баралтын коэффициент



Насны бүлэг дэх нас баралтын түвшинг сүүлийн 2 жилийн байдлаар авч үзэхэд 15-19, 25-29, 55-59 насны бүлэгт нас баралтын түвшин өмнөх оноос 0.3-1.7 промилээр их, бусад насны бүлэгт буурсан нь харагдаж байна.

4. Гэрлэлт

Гэрлэлт нь хүн амын гэр бүл болох явц, түүний өсөлт, өөрчлөлтийн хэмжээг харуулах бөгөөд өрх нэгдэх, тусгаарлах, зэрэг үйл явцыг илэрхийлдэг.

Хүснэгт 13. Бүртгүүлсэн гэр бүл, амьдарсан хугацаагаар

		2014	2015
<b>Бүртгүүлсэн гэр бүлийн тоо</b>		<b>519</b>	<b>554</b>
Үүнээс:	тайлант онд гэр бүл болсон	44	50
	тайлант оноос өмнө гэр бүл болсон	475	504
Үүнээс:	~жилийн өмнө	121	104
	~2-3 жилийн өмнө	169	196
	~4 ба түүнээс дээш жилийн өмнө	185	204

Аймгийн хэмжээнд бүртгүүлсэн гэр бүлийн тоо 2014 онд 519, 2015 онд 554 байгаа нь өмнөх оноос 6.7 хувиар буюу 35-аар их байна.

Бүртгүүлсэн гэр бүлийн тоог тайлант онд гэр бүл болсон, тайлант оноос өмнө гэр бүл болсон гэж 2 категорит хувааж үзвэл 2015 онд нийт бүртгүүлсэн гэр бүлийн 9.0 хувь буюу 50 нь тайлант онд, 91.0 хувь буюу 504 нь тайлант оноос өмнө гэр бүл болжээ.

Хүснэгт 14. Гэр бүлээ батлуулсан хүний тоо, нас, хүйсээр

	ЭРЭГТЭЙ		ЭМЭГТЭЙ	
	2014	2015	2014	2015
<b>БҮГД</b>	<b>519</b>	<b>554</b>	<b>519</b>	<b>554</b>
18-19 насны	10	5	6	12
20-24 насны	139	141	193	181
25-29 насны	195	239	172	200
30-34 насны	78	76	64	80
35-39 насны	36	39	31	35
40-44 насны	23	31	25	21
45-49 насны	23	15	18	19
50 ба дээш насны	15	8	10	6

Гэр бүлээ бүртгүүлсэн хүн амыг хүйсээр авч үзвэл эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд 20-29 насандаа гэр бүл болцгоодог нь хамгийн өндөр үзүүлэлттэй ба

40-өөс дээш насанд ч гэр бүл болох үзэгдэл нилээд байдаг байна.

Тухайн бүс нутгийн хүн амын гэрлэлтийн түвшин нийт хүн амын дотор эзлэх гэрлэсэн хүний хувийн жин зэрэг үзүүлэлт нь хүн амын доторх төрөлтийн түвшинд шууд нөлөөлнө. Гэрлэлтийн түвшингүүдийг авч үзье.

Гэрлэлтийн ерөнхий коэффициент (ГЕК) нь гэрлэлтийн түвшинг тодорхой хугацаанд тооцож, бусад бүс нутагтай зэрэгцүүлэх ерөнхий үзүүлэлт болдог. ГЕК нь тухайн жилийн 1000 хүнд ногдох гэрлэлтийн тоог харуулна.

Хүснэгт 15. Гэрлэлтийн түвшингүүд

Он	ГЕК	ЭРЭГТЭЙ (нас, хүйсийн бүлэг дэх ГК)							
		18-19 насны	20-24 насны	25-29 насны	30-34 насны	35-39 насны	40-44 насны	45-49 насны	50,+
2014	5.6	6.1	29.8	39.7	21.2	10.7	7.3	7.9	2.3
2015	5.8	3.5	31.5	48.2	18.8	11.3	9.4	4.9	1.1

2015 онд аймгийн хэмжээнд ГЕК нь 5.8

ХҮН АМ, ӨРХИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

байгаа нь 1000 хүн тутамд 6 гэрлэлт ногдож байгааг харуулна.

2015 оны ГЕК нь 2014 оноос 0.2 промилээр өссөн үзүүлэлттэй байна. ГЕК-ийн өсөлт, бууралт нь хүн амын тооны болон гэрлэлтийн өсөлт бууралтаас хамааралтай.

Он	ЭМЭГТЭЙ (нас, хүйсийн бүлэг дэх ГК)								ГТК
	18-19 насны	20-24 насны	25-29 насны	30-34 насны	35-39 насны	40-44 насны	45-49 насны	50,+	
2014	3.8	43.9	36.2	16.3	9	7	5.1	1.2	7.6
2015	8.6	42.2	41.1	19.5	10.1	5.7	5.2	0.7	7.8

Гэрлэлтийн тусгай коэффициентээр гэрлэх насны 1000 хүн тутамд ногдох гэрлэлтийн тоог

харуулдаг. ГТК 2015 онд 7.8 болж өмнөх оноос 0.2 промилээр нэмэгджээ. Өөрөөр хэлбэл гэрлэх насны 1000 хүн тутамд 8 гэрлэлт ногдож байна гэсэн үг юм.

Гэрлэлтийг гэрлэх нас, хүйсээр нь судлахын тулд *нас хүйсний бүлэг дэх гэрлэлтийн коэффициент (НХБГК)*-ийг тодорхойлдог. Энэ нь тодорхой нас, хүйсийн бүлгийн 1000 хүн ам тутамд ногдох тухайн нас, хүйсний бүлэг дэх гэрлэлтийн тоог илэрхийлнэ.

Энэ үзүүлэлт манайд эрэгтэйчүүдийн 25-29, эмэгтэйчүүдийн 20-24 насны бүлэгт хамгийн өндөр байна. Сүүлийн 2 жилийн байдлаар 20-24 насны бүлгийн эмэгтэйчүүдийн НХБГК нь 43.9-42.2, 25-29 насны эрэгтэйчүүдийн НХБГК нь 39.7-48.2 байна. Өөрөөр хэлбэл энэ насны 1000 эмэгтэйчүүдийн 44-42, 1000 эрэгтэйчүүдийн 40-48 нь гэрлэж байгааг харуулж байгаа юм.

### 5. Цуцлалт

Гэр бүл цуцлалт нь хүн амын ердийн хөдөлгөөний нэг үзүүлэлт болдог. Гэр бүл цуцлалтыг хамт амьдарсан хугацаагаар нь 7 бүлэгт хувааж үзлээ.

Хүснэгт 16. Гэр бүл цуцлалт, амьдарсан хугацаагаар

		2014	2015
<b>БҮГД</b>		<b>225</b>	<b>191</b>
Гэр бүл байсан хугацаагаар (жилээр)	1 хүртэл	1	1
	1-3	14	15
	4-6	51	43
	7-9	58	60
	10-14	33	25
	15-19	27	22
	20 ба дээш	41	25


Цуцалсан гэр бүлийн тоо 2015 онд 191 байгаагийн 31.4 хувийг 7-9 жил, 22.5 хувийг 4-6 жил, 13.1 хувийг 20 ба түүнээс дээш жил, 13.1 хувийг 10-14 жил, 11.5 хувийг 15-19 жил хамт амьдарсан хосууд эзэлж байна.

Цуцалсан гэр бүлийн тоо өмнөх оноос 15.1 хувиар буурчээ.

## ХҮН АМ, ӨРХИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Салалтын түвшинг авч үзье. *Салалтын ерөнхий коэффициент (СЕК)* нь гэр бүл салалтын хамгийн энгийн болон ерөнхий үзүүлэлт юм. Энэ нь тухайн бүс нутаг дээрх 1000 хүн амд ногдох салалтын тоог илэрхийлдэг.

Зураг 9. Салалтын түвшин



2015 онд СЕК 19.9 байгаа нь 2014 оноос 4.6 промилээс бага байна. Зургаас харахад салалтын түвшин 2012 онд хамгийн бага үзүүлэлттэй байсан бол 2014 онд хагийн өндөр үзүүлэлттэй байгаа нь харагдаж байна. Уг үзүүлэлт нь цуцлуулсан

гэр бүлийн тооны өсөлт, бууралтаас шууд хамаардаг.

### 6. Үрчлэлт

Үрчлэлт бол аль ч нийгмийн тогтолцооны үед амьдрал дээр гардаг үзэгдэл билээ. Иймээс үрчлэлтийг үрчлэгдсэн хүүхдийн насны бүлгээр нь авч судлав.

Хүснэгт 18. Үрчлэлт

		2014	2015
<b>БҮГД</b>		<b>73</b>	<b>57</b>
Үүнээс:	3 хүртэл насны	43	27
	3-6 насны	9	9
	7-9 насны	6	3
	10 ба дээш насны	15	18

Аймгийн хэмжээнд үрчлэгдсэн хүүхдийн тоо 2015 онд 57 болж өмнөх оноос 21.9 хувиар буюу 16 хүүхдээр буурсан байна.

Сүүлийн 2 жилд нийтдээ 130 хүүхэд үрчлэгдсэн байна. Үүний 53.8 хувь нь 3 хүртэл насны, 25.4 хувь нь 10 ба түүнээс дээш насны, 13.8 хувь нь 3-6 насны, 6.9 хувь нь 7-9 насны хүүхэд байна. Эндээс харахад 3 хүртэлх насны хүүхдийг үрчлэх, үрчлүүлэх явдал их байна.

### III. Өрх, хүн амын нийгмийн зарим үзүүлэлтүүд

#### 1. Өнчин болон хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхэд

Аймгийн хэмжээнд 2015 онд 143 бүтэн өнчин, 978 хагас өнчин хүүхэд байна. 0-18 хүртэлх насны нийт хүүхдийн 0.7 хувийг бүтэн өнчин, 4.7 хувийг хагас өнчин хүүхэд эзэлж байна.

#### Хүснэгт 19. Эмзэг бүлгийн хүүхдийн тоо

	2014	2015	
Бүтэн өнчин хүүхдийн тоо	155	143	2015 оны байдлаар бүтэн өнчин хүүхдийн 1.4 хувь нь 0-4 насны, 15.4 хувь нь 5-9 насны, 39.2 хувь нь 10-14 насны, 44.1 хувь нь 15-17 насны, хагас өнчин хүүхдийн 11.5 хувь нь 0-4 насны, 23.4 хувь нь 5-9 насны, 32.8 хувь нь 15-17 насны, 32.3 хувь нь 10-14 насны хүүхдүүд байна.
Хагас өнчин хүүхдийн тоо	910	978	
Хараа хяналтгүй тэнэдэг хүүхдийн тоо*	20	8	

**Тайлбар:** \* Хараа хяналтгүй тэнэдэг хүүхдийн тоог Цагдаагийн газрын мэдээгээр авсан.


Өмнөх оноос бүтэн өнчин хүүхдийн тоо 7.7 хувиар, хараа хяналтгүй тэнэдэг хүүхэд 60.0 хувиар буюу 12-оор буурч, хагас өнчин хүүхдийн тоо 7.5 хувиар нэмэгдсэн байна.

Өмнөх оноос бүтэн өнчин хүүхдийн тоо 7.7 хувиар, хараа хяналтгүй тэнэдэг хүүхэд 60.0 хувиар буюу 12-оор буурч, хагас өнчин хүүхдийн тоо 7.5 хувиар нэмэгдсэн байна.

#### 2. Өрх толгойлсон эмэгтэйчүүд.

Өрх тойлгойлсон эмэгтэйчүүдийн тоо 2015 онд 3032 байгаа нь 2014 оноос 4.3 хувиар нэмэгджээ.

#### Зураг 10. Өрх толгойлсон эмэгтэйчүүд




Эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн тоо нийт өрхийн 10.8 хувийг эзэлж байгаа нь өмнөх оноос 0.4 пунктээр буурсан байна.

**3. Хүүхэдтэй гэр бүлгүй хүн ам**

Хүүхэдтэй гэр бүлгүй хүн 2015 онд 1765 байгаагийн 89.1 хувь нь эмэгтэйчүүд байна.

Хүснэгт 20. Хүүхэдтэй гэр бүлгүй хүний тоо



Хүүхэдтэй гэр бүлгүй хүний тоо 2014 оноос 0.8, эхийн тоо 2.8 хувиар нэмэгдэж, эцгийн тоо 13.1 хувиар буурчээ.

## ДҮГНЭЛТ

Хүн ам, орон сууцны завсрын тооллого 2015 онд явагдаж, хүн амыг бүртгэлд суурилсан аргаар тоолов. Тооллогын дүнгээр Орхон аймгийн хүн амын тоо өмнөх жилээс 6.5 хувиар, Баян-Өндөр сумын хүн ам 7.1 хувиар өсч, Жаргалант сумын хүн ам 6.5 хувиар буурсан байна. Сүүлийн 2 жилийн байдлаар цэвэр шилжилт хасах, цэвэр өсөлт нэмэх үзүүлэлттэй байгаа нь хүн амын тооны өсөлтөд ердийн цэвэр өсөлт шууд нөлөөлж буйг илтгэнэ.

Нийт багийн 76.0 хувь нь 3.0 мянгаас дээш хүн амтай байна.

Нийт хүн амд 0-15 насны хүүхдийн эзлэх хувь 2014 оноос 2.2 пунктээр нэмэгдэж, хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь 2.2 пунктээр буурч, тэтгэврийн насны хүн ам өмнөх оны түвшинд байна. Энэ нь хүн амын насны бүтцэд өөрчлөлт гарч байгааг харуулж байна.

Хөдөлмөрийн насны 100 хүнд ногдож байгаа тэжээлгэгчийн тоо өмнөх оноос 5.2 нэгжээр нэмэгджээ.

Аймгийн хүн амын хүйсийн харьцаа 96.49 ба өмнөх оноос 0.3 нэгжээр нэмэгдсэнийг нийт хүн амд эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин 0.1 пунктээр өссөнтэй холбон үзэж болох юм.

Аймгийн нийт өрхийн тоо өмнөх оноос 8.1 хувиар нэмэгдсэн ба багуудын 64.0 хувь нь 1.0 мянгаас дээш өрхтэй, 16.0 хувь нь 350 хүртэл өрхтэй байна. Нийт өрхөд аймгийн төвд амьдарч байгаа өрхийн эзлэх хувийн жин өмнөх оноос 0.7 пунктээр нэмэгдэж, хөдөөгийн өрх 0.6 пунктээр, сумын төвийн өрх 0.1 пунктээр буурсан байна.

Нийт өрхийн 10.8 хувь нь эмэгтэй тэргүүлэгчтэй өрх байна.

Нэг өрхөд ногдох хүний тоо аймаг, сумын төвд ойролцоо 3.5 байхад хөдөөд 2.8 байна. Энэ нь төв суурин газрын хүн амын нягтшил их байгааг илтгэнэ.

Аймгийн нэг км<sup>2</sup> нутаг дэвсгэрт 117 хүн ногдож, хүн амын нягтрал улсын дунджаас 58.5 дахин их байна. Нэг км<sup>2</sup> нутаг дэвсгэрт ногдох хүний тоо Баян-Өндөр суманд 474.9 байхад Жаргалант суманд 4.7 байгаа нь аймгийн дунджаас Баян-Өндөр сумынх 4.1 дахин их, Жаргалант сумынх 24.9 дахин бага байна.

Энэ онд 2352 хүүхэд төрсөн нь өмнөх оноос 6.5 буурсан ба төрсөн нийт хүүхдийн 51.2 хувийг эрэгтэй хүүхэд эзэлж байна. Төрөх үеийн хүйсийн харьцаа

2015 онд 105.1 ба өмнөх оноос 0.4 пунктээр буурсан нь шинээр төрсөн нийт хүүхдийн дүнд эрэгтэй хүүхдийн эзлэх хувийн жин буурсаныг харуулж байна.

Өмнөх оноос төрөлтийн ерөнхий коэффициент 2.8, төрөлтийн тусгай коэффициент 7.4, төрөлтийн нийлбэр коэффициент 0.2 промилээр буурчээ. Эдгээр бууралтад хүн амын тоо өссөн, төрөлт буурсан нь шууд нөлөөлж байна.

Нийт нас барсан хүний 63.3 хувийг эрэгтэйчүүд эзэлж байгаа нь өмнөх оноос 3.8 пунктээр нэмэгдсэн байна. Тайлант онд 1000 хүн тутмын 5.8 нь нас барж, өмнөх оноос 1.0 промилээр буурчээ.

Аймгийн хэмжээнд ГЕК нь 5.8 байгаа 2014 оноос 0.2 промилээр нэмэгдсэн байна. Харин СЕК 19.9 байгаа нь 2014 оноос 4.6 промилээс бага байна.

Өмнөх оноос бүтэн өнчин хүүхдийн тоо 7.7 хувиар, хараа хяналтгүй тэнэдэг хүүхэд 60.0 хувиар буурч, хагас өнчин хүүхдийн тоо 7.5 хувиар нэмэгдсэн байна.

### **Хамруулсан хугацаа:**

Үзүүлэлтүүдийг ихэвчлэн 2014-2015 оноор, зарим шаардлагатай үзүүлэлтийг 2011-2015 оны байдлаар авч, өсөлт, өөрчлөлтийг өмнөх онтой харьцуулан тодорхойлов.

### **Мэдээллийн эх үүсвэр.**

- Хүн амын жилийн эцсийн 2014 оны тайлан (ХА-3)
- Хүн ам, орон сууцны завсрын тооллогын дүн, 2015 он
- Хүн амын ердийн хөдөлгөөний 2014, 2015 оны жилийн тайлан (ХА-1)
- Өрх, хүн амын нийгмийн зарим үзүүлэлтийн 2014, 2015 оны тайлан (НС-1)
- Аймгийн Статистикийн бюллетень, 2015 он

**Нэр томъёоны тайлбар:**

- **Суурин хүн ам.** Тухайн баг, хорооны нутаг дэвсгэрт 6 сараас дээш хугацаагаар оршин суугаа бүх хүнийг суурин хүн ам гэнэ. Мөн 6 сараас доош хугацаагаар түр эзгүй байгаа байнга оршин суудаг хүмүүсийг суурин хүн амын бүртгэлд оруулна.
- **Өрх.** Ураг төрлийн болон гэр бүлийн холбоотой нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг бүлэг хүмүүсийг өрх гэж үзнэ.
- **Нэг өрхөд ногдох хүний тоо.** Нэг өрхөд ногдох хүний тоог тодорхойлохдоо өрхөд тоологдсон хүний тоог өрхийн тоонд харьцуулна.
- **Хүйсийн харьцаа.** Хүйсийн харьцаа гэсэн үзүүлэлт нь 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоог илэрхийлдэг.
- **Хүн ам зүйн ачаалал.** Хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох тэжээлгэгчийн тоог харуулдаг.
- **Насны голч.** Хүн амыг насны бүтцийнх нь хувьд яг голлон хувааж байгаа насыг нэсны голч гэнэ.
- **Хүн амын нас-хүйсийн суварга.** Судалгаанд хүн амын нас, хүйсийн суваргаар нас, хүйсийн бүтцийг зураглан харуулдаг. Энэ нь зэрэгцүүлэхэд хялбар, хүйсний ялгавараар төв абцисс тэнхлэгээс хамгийн залуугаас эхлэн насны өсөх дарааллаар, доороос дээш суварган хэлбэртэй байна. Нас, хүйсний бүлэг бүр 100 хувьтай тэнцүү байна.
- **Төрөлтийн ерөнхий коэффициент.** Энэ үзүүлэлт нь тухайн жилд 1000 хүн амд ногдох амьд төрсөн хүүхдийн тоог илэрхийлдэг бөгөөд амьд төрсөн хүүхдийн тоог тухайн жилийн дундаж хүн амд харьцуулдаг.
- **Төрөлтийн тусгай коэффициент.** Төрөх насны буюу 15-49 насны 1000 эмэгтэйчүүдэд ногдох амьд төрсөн хүүхдийн тоог илэрхийлдэг.
- **Төрөлтийн нийлбэр коэффициент.** Төрөх насны эмэгтэйн төрүүлсэн нийт хүүхдийн дундаж тоо бөгөөд 1 эмэгтэйн эсвэл 1000 эмэгтэйн нийт амьдралынхаа туршид төрүүлэх дундаж хүүхдийн тоог илэрхийлдэг.

- **Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент.** Тухайн насны бүлгийн эмэгтэйчүүдийн амьд төрүүлсэн хүүхдийн тоог мөн насны бүлгийн эмэгтэйчүүдэд харьцуулсан харьцаа
- **Нас баралтын ерөнхий коэффициент.** Нас барсан хүний тоог тухайн жилийн дундаж хүн амд харьцуулсан харьцаа бөгөөд энэ үзүүлэлт нь 1000 хүн амд ногдох нас баралтын тоог илэрхийлдэг.
- **Насны бүлэг дэх нас баралтын коэффициент.** Тухайн насны бүлэгт нас барсан хүний тоог мөн насны бүлгийн хүн амд харьцуулсан харьцаа
- **Батлуулсан гэр бүлтэй.** Гэрлэлтээ иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлсэн, гэрлэлтийн баталгаатай хүмүүсийг “Батлуулсан гэр бүлтэй” буюу гэр бүлтэй гэнэ.
- **Салсан.** Гэр бүлээ хуулийн дагуу цуцалснаас хойших хугацааг харгалзахгүйгээр дахин гэрлээгүй хүмүүсийг салсан гэж тодорхойлдог.
- **Гэрлэлтийн ерөнхий коэффициент.** Иргэний гэр бүлийн байгууллагад тухайн жилд бүртгүүлсэн гэр бүлийн тоог тухайн жилийн дундаж хүн амд харьцуулсан харьцааг илэрхийлсэн үзүүлэлт.
- **Гэр бүл цуцлалтын ерөнхий коэффициент.** Шүүхийн болон захиргааны шийдвэрээр гэр бүл цуцлагдаж, тухайн жилд иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлсэн гэр бүлийн тоог тухайн жилийн дундаж хүн амд харьцуулсан харьцаагаар илэрхийлэгддэг.
- **Өнчин болон онц хүнд нөхцөлд байгаа хүүхдийн тоо.** Өнчин хүүхдийн тоог тодорхойлохдоо бүтэн өнчинд эцэг, эх 2 нь хоёулаа нас барсан хүүхдийг, хагас өнчинд эцэг, эхийн аль нэг нь нас барсан хүүхдийг оруулж бүртгэнэ. Бутач хүүхэд, гэр бүл салалтын улмаас эцэг, эхийн аль нэгтэй хамт амьдарч байгаа хүүхдийг өнчин хүүхдэд оруулахгүй. “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай” Монгол Улсын хуулийн 15 дугаар зүйлийн 1-д “ЫБайгалийн гамшиг, гоц халдварт өвчин, нийтийг хамарсан гэнэтийн осол, зэвсэгт мөргөлдөөнд өртсөн, амиа хорлохыг оролдлого хийсэн хүүхдийг онцгой нөхцөлд байгаа хүүхэд гэж үзнэ” гэж тодорхойлсон байдаг.
- **Өрх толгойлсон хүний тоо.** Гэр бүлгүй, өрх толгойлон амьдарч байгаа хүн амыг хүүхэдтэй эсэхийг харгалзахгүйгээр хамруулна.

ХҮН АМ, ӨРХИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

- **Хүүхэдтэй гэр бүлгүй хүн ам.** *Гэр бүлгүй, 16 хүртэл насны хүүхэлтэй эрэгтэй болон эмэгтэй хүнийг эцэг, эх, хамаатан садангийн хэнтэй амьдарч байгааг харгалзахгүйгээр хамруулж тооцно.*

ОРХОН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛ, СТАТИСТИКИЙН ГАЗРЫН  
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2016 он